



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/12

Шивээговь сум

Гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Улсын Их Хурлаас баталсан 2002 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Засаг даргын 2007 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 24 дүгээр “Газар өмчлүүлэх тухай захирамжаар гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн иргэн Лувсанцэндийн Баттулга, Гонгорын Золбоо нарын өмчлөлд байгаа 1 дүгээр баг, төвд байрлах газрыг “Газар өмчлөлөөс хамтран өмчлөгч хасуулах хэлцэл”-ийн дагуу дундын өмчлөлөөс газар өмчлөх эрхийг шилжүүлэн авч байгаа иргэн Дух овогт Гонгорын Золбоо /РД: ЕУ88031811/-д Шивээговь сумын 1 дүгээр баг, төвийн эгнээнд байрлах 0,07 га /700 м.кв/ бүхий газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлсүгэй.

2.Газар өмчлөлийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2007 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 24 тоот захирамжийн хавсралтын 4 дэх бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Лувсанцэндийн Баттулгад хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ